**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН**
**ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**
**ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 30 өдөр          Дугаар 23/10          Арвайхээр сум

Зорилтот жил зарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.2024 оныг "Цахим шилжилтийг эрчимжүүлэх" жил болгон зарласугай.

2."Цахим шилжилтийг эрчимжүүлэх" жилийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнахыг аймгийн Засаг даргын үүрэг гүйцэтгэгч (И.Доржсүрэн)-д даалгасугай.

3."Цахим шилжилтийг эрчимжүүлэх" жил болгон зарласантай холбогдуулан орон нутгийн хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулж, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА          О.ПҮРЭВДОРЖ

D:/ИТХ/nuuts2023/1.togtool/togtool.dock

622301160